



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар A/55

Модот

Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 21.3.1, 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Тус сумын нутаг дэвсгэрт байгаа төлөвлөгөөт мал, амьтныг угаалга, туулгалт, боловсруулалтад хамруулах арга хэмжээг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2.Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн графикт хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн захирал, малын эмч нарт, товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгах, бүрэн хамруулах, тарилгын хашааг барих зэрэг ажлыг малчдаар бэлтгүүлэх ажлыг Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, нэгдсэн тайлан дүн мэдээг Мал эмнэлгийн газарт хүргэж ажиллах, уг арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (П.Ганчимэг) -т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ



